

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2022/46/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Назгүл
Утас: 99427301 Цахим хаяг: nazgul_1972@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага.....	18
5.3 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

БУЛГАН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 1 ДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
А. НУРЖАН ТАНАА

2023.02.09 № 42
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан, баталж ажиллаагүй байна.

Аудитын гол асуудал

2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дүгнэлт-Булган ЕБС I-ТА

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>99,435,936.00</u>	<u>161,071,204.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	35,564,669.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	35,564,669.00
3121	Төгрөг	-	35,564,669.00
31211	Төрийн сангийн харилцах	-	35,564,669.00
33	АВЛАГА	-	513,165.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	513,165.00
34	УРЬДЧИЛГАА	-	22,227,350.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	22,227,350.00
35	БАРАА МАТЕРИАЛ	99,435,936.00	102,766,020.00
354	Хангамжийн материал	99,435,936.00	102,766,020.00
35420	Аж ахуйн материал	46,455,520.00	46,235,620.00
35440	Түлш, шатах тослох материал	19,710,000.00	3,500,000.00
35460	Хүнсний материал	33,270,416.00	53,030,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,281,691,405.62</u>	<u>2,845,359,947.10</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,281,691,405.62	2,845,359,947.10
392	Биет хөрөнгө	2,226,049,405.62	2,789,717,947.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,315,418,562.04	2,895,338,088.04
39202	Хуримтлагдсан элэгдэл	(204,816,265.92)	(273,631,053.96)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	165,848,665.00	231,903,665.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(126,886,571.72)	(137,541,571.44)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	94,577,933.00	98,577,933.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(57,066,300.85)	(64,246,083.17)
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,635,848.95	15,635,848.95
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,506,428.88)	(2,259,643.32)
39217	Ном	24,843,964.00	25,940,764.00
393	Биет бус хөрөнгө	55,642,000.00	55,642,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	56,192,000.00	56,192,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,381,127,341.62</u>	<u>3,006,431,151.10</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,381,642,118.62</u>	<u>3,006,431,151.10</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,381,642,118.62	3,006,431,151.10
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	599,304,069.00	599,304,069.00
51101	Өмч: - төрийн	599,304,069.00	599,304,069.00
512	Хуримтлагдсан үр дүн	(513,991,728.49)	110,797,303.99
51210	Өмнөх үеийн үр дүн	(513,991,728.49)	(513,991,728.49)
51220	Тайлант үеийн үр дүн	-	624,789,032.48
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,296,329,778.11	2,296,329,778.11
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,381,642,118.62</u>	<u>3,006,431,151.10</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			Төгрөгөөр	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,879,973,600.00	2,942,504,326.00	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,985,000.00	345,500.00	
120	Нийтлэг татварын бус орлого	17,985,000.00	345,500.00	
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	17,985,000.00	345,500.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	17,985,000.00	345,500.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,861,988,600.00	2,942,158,826.00	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,789,061,460.00	2,750,166,826.00	
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	2,143,950,500.00	
131005	Хөрөнгийн санхүүжилт	39,278,160.00	606,216,326.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,749,783,300.00	-	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,012,140.00	-	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,012,140.00	-	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	71,915,000.00	191,992,000.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	71,915,000.00	191,992,000.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,907,225,631.01	2,317,715,293.52	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,890,212,471.01	2,317,715,293.52	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,858,233,321.01	2,252,236,678.52	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,399,852,102.00	1,662,099,104.00	
210101	Үндсэн цалин	1,270,591,102.00	1,286,082,602.00	
210102	Нэмэгдэл	-	322,897,102.00	
210104	Урамшуулал	79,345,300.00	53,119,400.00	
210105	Гэрээт ажлын хөлс	49,915,700.00	-	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	182,206,880.00	208,210,194.00	
210201	Тэтгэврийн даатгал	121,068,086.00	141,373,494.00	
210202	Тэтгэмжийн даатгал	15,280,127.00	17,937,735.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,235,108.00	12,259,403.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	3,063,315.00	3,355,907.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	30,560,244.00	33,283,655.00	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,343,809.00	106,530,112.00	
210301	Гэрэл, цахилгаан	3,601,964.00	5,556,545.00	
210302	Түлш, халаалт	72,741,845.00	100,973,567.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	20,279,290.00	6,838,010.00	
210401	Бичиг хэрэг	5,769,840.00	2,893,500.00	
210402	Тээвэр, шатахуун	3,250,000.00	-	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	816,300.00	-	
210404	Ном, хэвлэл	21,000.00	-	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,422,150.00	3,944,510.00	
2105	Нормативт зардал	82,228,575.00	127,768,291.60	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	396,200.00	-	
210502	Хоол, хүнс	75,802,134.00	127,768,291.60	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,030,241.00	-	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,305,000.00	-	
210604	Урсгал засвар	1,305,000.00	-	
2107	Томилолт, зочны зардал	540,400.00	-	

210702	Дотоод албан томилолт	540,400.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	768,900.00	4,835,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	168,900.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	4,835,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	94,708,365.01	135,955,966.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	38,603,892.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,171,400.00	9,949,290.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	85,536,965.01	87,402,784.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,979,150.00	65,478,615.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,279,150.00	65,022,290.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,279,150.00	65,022,290.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	700,000.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	700,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	456,325.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	456,325.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,013,160.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	17,013,160.00	-
225101	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) /ТӨҮГ/	17,013,160.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(27,252,031.01)	624,789,032.48
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(27,252,031.01)	624,789,032.48

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,822,710,440.00	2,335,942,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,822,710,440.00	2,335,942,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,749,783,300.00	2,143,950,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		2,143,950,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,749,783,300.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,012,140.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,012,140.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	71,915,000.00	191,992,000.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	71,915,000.00	191,992,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,821,071,440.00	2,255,522,831.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,821,071,440.00	2,255,522,831.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,788,372,940.00	2,190,977,341.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,417,813,500.00	1,662,312,486.00
210101	Үндсэн цалин	1,289,252,500.00	1,240,960,748.00
210102	Нэмэгдэл		378,191,831.00
210104	Урамшуулал	79,345,300.00	43,159,907.00
210105	Гэрээт ажлын хөлс	49,215,700.00	-

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	191,499,500.00	207,995,200.00
210201	Тэтгэврийн даатгал	134,758,800.00	141,436,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	14,185,200.00	16,639,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,348,100.00	13,311,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,837,100.00	3,327,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	28,370,300.00	33,279,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,915,000.00	92,033,512.00
210301	Гэрэл, цахилгаан	5,151,000.00	5,651,000.00
210302	Түлш, халаалт	65,764,000.00	86,382,512.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,275,340.00	-
210401	Бичиг хэрэг	1,005,040.00	-
210402	Тээвэр, шатахуун	3,250,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	816,300.00	-
210404	Ном, хэвлэл	675,500.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,528,500.00	-
2105	Нормативт зардал	89,799,500.00	148,496,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	528,300.00	-
210502	Хоол, хүнс	85,888,300.00	148,496,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,382,900.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,100,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,100,000.00
2107	Томилолт, зочны зардал	540,400.00	-
210702	Дотоод албан томилолт	540,400.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,275,500.00	6,651,350.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	675,500.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		6,651,350.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,254,200.00	72,387,893.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		56,211,103.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,254,200.00	16,176,790.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,698,500.00	64,545,490.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,998,500.00	64,089,165.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,998,500.00	64,089,165.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	700,000.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	700,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	456,325.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		456,325.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,639,000.00	80,419,669.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,639,000.00	44,855,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,639,000.00	44,855,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,639,000.00	44,855,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,639,000.00	44,855,000.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,639,000.00)	(44,855,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	35,564,669.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		35,564,669.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	599,304,069.00	2,296,329,778.11	-513,991,728.49	2,381,642,118.62
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	599,304,069.00	2,296,329,778.11	-513,991,728.49	2,381,642,118.62
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	599,304,069.00	2,296,329,778.11	-513,991,728.49	2,381,642,118.62
D08	Тайлант үеийн үр дүн			624,789,032.48	624,789,032.48
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	599,304,069.00	2,296,329,778.11	110,797,303.99	3,006,431,151.10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Үзүүлэлт	Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,335,942,500.00	2,299,921,506.00
УРСГАЛ ЗАРДАЛ	2,335,942,500.00	2,299,921,506.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,266,442,500.00	2,235,832,341.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,685,407,200.00	1,662,312,486.00
Үндсэн цалин	1,295,991,000.00	1,240,960,748.00
Нэмэгдэл	341,682,400.00	378,191,831.00
Урамшуулал	47,733,800.00	43,159,907.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	209,682,700.00	207,995,200.00
Тэтгэврийн даатгал	142,584,400.00	141,436,900.00

Тэтгэмжийн даатгал	16,774,600.00	16,639,600.00
ҮОМШӨ-ний даатгал	13,419,700.00	13,311,700.00
Ажилгүйдлийн даатгал	3,354,800.00	3,327,800.00
Эрүүл мэндийн даатгал	33,549,200.00	33,279,200.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92,051,000.00	92,033,512.00
Гэрэл, цахилгаан	5,651,000.00	5,651,000.00
Түлш, халаалт	86,400,000.00	86,382,512.00
Нормативт зардал	148,496,900.00	148,496,900.00
Хоол, хүнс	148,496,900.00	148,496,900.00
Эд хогшил, урсгал засварын зардал	1,100,000.00	1,100,000.00
Урсгал засвар	1,100,000.00	1,100,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,065,500.00	10,051,350.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,065,500.00	10,051,350.00
Бараа үйлчилгээний бусад зардал	118,639,200.00	113,842,893.00
Бараа үйлчилгээний бусад зардал	102,041,000.00	97,666,103.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,598,200.00	16,176,790.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,500,000.00	64,089,165.00
Бусад урсгал шилжүүлэг	69,500,000.00	64,089,165.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	69,500,000.00	64,089,165.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,335,942,500.00	2,335,486,175.00
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,143,950,500.00	2,143,950,500.00
Улсын төсвөөс санхүүжих	2,143,950,500.00	2,143,950,500.00
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	191,992,000.00	191,535,675.00
Орон нутгийн төсвөөс	191,992,000.00	191,535,675.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		35,564,669.00
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
Төсвийн байгууллага	1	1
АЖИЛЛАГСАДЫН ТОО	119.00	122.00

Удирдах ажилтан	1	1
Гүйцэтгэх ажилтан	77	80
Үйлчлэх ажилтан	41	41
Гэрээт ажилтан		
СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	780.00	809.00
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	780.00	809.00
Төрийн өмчит ЕБС	780	809
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	119.00	122.00
СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	77	80
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	42	42

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсөв аваагүй

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Булган сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь ерөнхий боловсрол олгох чиг үүрэгтэй байгууллага.

Сургууль нь 2022 онд “Багш мэргэжилтний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, бага боловсрол эзэмшүүлэх, чанартай сургалт явуулах, хууль шинжлэх ухааны үндэслэлийг ахиулахад онцгой анхаарах” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах
- Сургалтын чанар, хүртээмжийг сайжруулах
- Мэдлэг чадвараа дээшлүүлэх
- Эрүүл аюулгүй орчинд суралцах нөхцөл бүрдүүлэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Булган сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль болон бусад боловсролын байгууллагуудад мөрдөж байгаа хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Улсын Их Хурлаас Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр боловсролын салбарын байгууллагууд улсын төсвөөс санхүүжиж, БСШУС-ын харьяа Боловсролын ерөнхий газарт санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Булган сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Булган сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 624.8 сая төгрөгөөр буюу 26.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	35564.67	35,564.67
Авлага	514.78	513.17	-1.61
Урьдчилгаа	0.00	22227.35	22,227.35
Бараа материал	99435.94	102766.02	3,330.08
Үндсэн хөрөнгө	2281691.41	2845359.95	563,668.54
Нийт хөрөнгө	2,381,642.12	3,006,431.15	624,789.03
Өр төлбөр	2381642.12	3006431.15	624,789.03
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	0.00	0.00	0.00
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2381642.12	3006431.15	624,789.03

Эх сурвалж: Аудитын судалгаа

Мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 35.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь цалин, НДШ, бараа үйлчилгээний зардал, үдийн цайны зардлуудыг хэмнэлттэй зарцуулсантай холбоотой ба үүнээс цалин, НДШ-ийн зардлын хэмнэлт 24.8 сая төгрөг байна.

Оны эцэст урьдчилгаа данс 22.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь цахим худалдан авалтаар авсан хөрөнгийг хүлээж аваагүй байгаа тул урьдчилгаа дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын данс 3.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь хүнсний материалын орлоготой холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 585.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 67.0 сая, үнэ төлбөргүй 606.2 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч үндсэн хөрөнгөнд тайлант онд 87.4 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Тайлант онд 624.8 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 624.81 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,361.8 сая, орон нутгийн төсвөөс 91.5 сая, нийт зарлагыг 2,453.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж Төсвийн төслийн саналаас 819.9 сая төгрөгөөр 1,633.4 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт 6, 9, 11, 12 дугаар саруудад тодотгол хийж төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,143.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 191.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,143.9 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 191.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,299.9 сая төгрөг буюу 98.4 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний зардлын төсвийг 0.4 сая, үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 35.6 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний зардлын зориулалт	196,418.2	195,975.4	-442.80	90.00%
2	Бараа үйлчилгээний бусад нийтлэг зардлын зориулалт	2,213.10	2,213.10	0.00	100.00%
3	Эрүүл мэндийн арга хэмжээ	5,090.10	5,090.10	0.00	100.00%
4	Үдийн цай	69,500.0	64,089.2	-5,410.8	92.2%
5	Дотуур барны үйлчилгээ	230,707.7	230,678.4	-29.3	99.9%
6	Хүүхдэд ээлтэй орчин	67,435.0	63,682.4	-3,752.7	94.4%
7	Боловсролын байгууллагын багш, ажиллагсадын мэргэжил дээшлүүлэх	9,958.9	9,958.9	0,00	100%
8	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,507,229.5	1,488,232.9	-18,996.6	98.7%
9	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	247,390.0	240,000.5	-7389.5	97%
	Дүн	2,335,942.50	2,299,921.60	-36,020.90	98.46%

Эх сурвалж: Аудитын судалгаа

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Булган сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 2022 онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Булган сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Булган сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Булган сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,890.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 37.8 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэх үе шатанд материаллаг байдлыг Булган сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,317.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 46.3 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

Булган сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал өмнөх оноос 427.5 сая төгрөгөөр нэмэгдсэн тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоох нь зүйтэй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага бараа, ажил үйлчилгээний зардлыг хэмнэлттэй зарцуулсан байна. Тухайлбал: Цалингийн зардлыг 23.1 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1.7 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 1.0 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 4.8 сая, үдийн хоолны зардлыг 5.4 сая, нийт 36.0 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад дараах алдаа, зөрчил илэрч албан шаардлага өгсөн. Үүнд:

1. БСШУС-ын сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/024/11 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив”-ыг зөрчиж хичээл зохицуулагчийн 1 орон тоог ажиллуулж 5.1 сая төгрөгийн үргүй зардал гаргасан байна.

2. Батлагдсан орон тооны хязгаарыг хэтрүүлж англи хэлний болон хөдөлмөрийн хичээлийн багшын орон тоог илүү ажиллуулж 24.1 сая төгрөгийн үргүй зардал гаргасан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 87.5%, хугацаа хоцролтын хэрэгжилтийн хувь 83.3% байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар эхний хагас жилийн баримтыг хүлээн авч түүвэр хийсэн. Завсрын аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар санхүүгийн тайлангийн аудитаар шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.4.4, 6.4.6, 6.4.8 -д заасан 30.8 сая төгрөгийн 6 мэдээллийг байршуулаагүй, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад зардлын батлагдсан төсвийн 15.9 сая төгрөгийн 10 хувиар буюу 1.5 сая төгрөгөөр хэмнэлт гаргаж ажиллаагүй зөрчлүүдэд албан шаардлага, бараа үйлчилгээний зардлын гүйлгээг тооцоо үүсгэж, бүртгэж тайлагнах, шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгах талаар зөвлөмж өгөгдсөн.

Өмнөх аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0	0	0	0
Албан шаардлага	2	32300.0	2	32300.0	100%
Зөвлөмж	1	17300.0	1	17300.0	100%
Нийт дүн	3	49600.0	3	49600.0	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах бусад асуудал байхгүй байна..

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 89.3 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 89.3 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд:

Мөнгөн гүйлгээний тайлангийн биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардлыг 22.2 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 22.2 сая төгрөгөөр зөрүүтэй, үндсэн хөрөнгийн машин тоног төхөөрөмжийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан дүнг 22.2 сая, урьдчилж гарсан зардлыг 22.2 сая төгрөгөөр төсвийн гүйцэтгэлийн тайлангийн цалингийн батлагдсан төлөвлөгөөг 63 төгрөгөөр, төлөвлөгөө, гүйцэтгэлийг 0.4 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасныг залруулсан.

Аудитаар нийт 2.1 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 1.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 0.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1 заалт бүхий зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Төлбөрийн акт

ҮАГ-ын боловсролын ТЕЗ-д аудит хийх багаас ирүүлсэн анхаарах асуудлуудын хүрээнд шалгаж Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35, А/10, 9 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт” -ийг зөрчиж ур чадварын нэмэгдэл олгосон 1.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитаар дараах зөрчлийн дүнгээр албан шаардлага өгөгдлөө.

1. Ур чадвар олгох шалгуур үзүүлэлтийн дагуу хагас жил тутамд сургуулийн захирал нь шалгуур үзүүлэлтэд заасны дагуу хамт олны оролцоог хангаж багш, ажилтны ур чадварыг үнэлж байх ёстой боловч хэрэгжүүлээгүй, 2022 онд шалгуурын дагуу үнэлгээ хийлгүй нэг багшид 0.9 сая төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон.

2. Үйлчилгээний албан хаагчдад ур чадварын үнэлгээ хийгээгүй, ур чадварын нэмэгдэл олгоогүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

2.1.Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй, сургуулийн удирдлага болон нягтлан бодогч нь санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар ойлголт, мэдээлэлгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг", 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалттай нийцээгүй, АОУС-250-д "Санхүүгийн тайланд хууль тогтоомж, дүрэм, журмыг анхаарах", УСНББОУС-1, АДБОУС 200 болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

2.2.Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийн хангаж нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж санхүү, бүртгэл, тайлагналын үйл ажиллагаандаа ашиглах, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нар санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаарх мэдээлэл, ойлголтоо сайжруулах;

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланг алдаатай илэрхийлсэн	5	89349.8			5	89349.8	5	89349.8				
Дүн	5	89349.8			5	89349.8	5	89349.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгуул агад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шалгуур үзүүлэлт хангаагүй үр чадварын нэмэгдэл авсан	1	1152.9	1	1152.9								
Ажилтнуудын үр чадварыг үнэлээгүй, шалгуур үзүүлэлт хангаагүй багшид үр чадварын нэмэгдэл олгосон.	1	929.1			1	929.1						
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй, сургуулийн удирдлага болон нягтлан бодогч нь санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар ойлголт, мэдээлэлгүй	1	0.0					1					
Дүн	3	2082.0	1	1152.9	1	929.1	1					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс		Зөвлөмж		
							Тоо	Дүн	Тоо	Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил											
Дүн											
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил											
1.Жишиг норматив"-ыг зөрчиж хичээл зохицуулагчийн 1 орон тоог ажиллуулж үргүй зардал гаргасан байна 2.Батлагдсан орон тооны хязгаарыг	1	29237.7					1	29237.7			

хэтрүүлж англи хэлний болон хөдөлмөрийн хичээлийн багшийн орон тоог илүү ажиллуулсан.								
Дүн	1	29237.7			1	29237.7		
Нийт дүн	1	29237.7			1	29237.7		